

ТАНИЛЦУУЛГА

Ажил мэргэжлийн жишиг цалингийн хэмжээг шинэчлэн батлах тухай

2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Даатгуулагчийн 1995 оноос өмнөх үеийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого нь архивын баримтаар нотлогдох боломжгүй тохиолдолд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзан нийгмийн даатгалын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан ажил, мэргэжлийн жишиг цалинд үндэслэн тэтгэвэр тогтоолгох сарын дундаж хөдөлмөрийн хөлсийг тодорхойлж болно” гэж заасан.

Дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлэхээр Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/49, А/105 дугаар тушаалаар хамтран баталж, хэрэгжилтийг зохион байгуулж байна.

Үндэсний статистикийн хорооны тооцооноор ажиллагсадын дундаж цалингийн хэмжээ 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар 1314.9 мянган төгрөг байгаа нь 2016 оны мөн үетэй харьцуулахад 50.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.¹

Иймд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/49, А/105 дугаар тушаалаар хамтран баталсан “Ажил мэргэжлийн жишиг цалингийн хэмжээ”-г шинэчлэн батлах зайлшгүй шаардлагатай байна.

Ажил мэргэжлийн жишиг цалингийн хэмжээ шинэчлэгдэн батлагдсанаар Нийгмийн даатгалын сангийн төсөвт нэмэлт зардал гарахгүй.

---oOo---

¹ www.1212.mn